



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/570

Булган сум

Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалт
явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, Монгол улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийн цэргийн бэлтгэл сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 19-өөс 09 дүгээр сарын 28-ны хугацаанд Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийг түшиглэн зохион байгуулсугай.


2.Цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдтэй сургалт зохион байгуулах бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, зарцуулах хөрөнгийн төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Сургалтад шаардагдах 11,580,000 (арван нэгэн сая таван зуун наян мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

4.Цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдтэй явуулах сургалтыг хугацаанд нь зохион байгуулж, дүнг 10 дугаар сарын 05-ны дотор илтгэхийг Цэргийн штаб (дэд хурандаа Т.Нямхүү)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Д.ГҮРЭВ-ОЧИР



6325010782

09 Аймгийн Засаг даргын 2025 оны
сарын 02 ны өдрийн 179 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ СУРГАЛТЫГ
ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Сургалтын удирдагч	Дэд хурандаа Т.Нямхүү - ЦШ-ын дарга
Сургалтын төвийн захирал	д/х Б.Намнансүрэн - ЦШ-ын ОНХС-ын офицер
Багш нар	х/ч Ц.Цэрэнтогтох - ЦШ-ын Дайчилгааний офицер
	х/ч Г.Эрдэнэхүү - 234-р ангийн офицер
	д/ч Э.Бадрал - Онцгой байдлын газар
Жагсаалын дарга	а/а Н.Амарсанаа - Онцгой байдлын газар
Тогооч	Д.Оюунсайхан - Энгийн

Аймгийн Засаг даргын 2025 оны
09 сарын 02 ны өдрийн 4570 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

СУРГАЛТАД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ	Тайлбар
1	Хоолны үнэ	9,000,000	Цэргийн албан хаагчийн хоногийн хоолны нормоор 18000 төг*50хүн *10 хоног
2	Багш нар, тогоочийн цалин	2,000,000	5 хүн*40000 төг*10 хоног
3	Бичиг хэргийн зардал	175,000	Дэвтэр, бал 1хүн*50* 3500 төг
4	Шатахуун	408,000	150л АИ-92 2720
Нийт			11,580,000